

ИНД - 171

**Нисэхийн цахилгаан холбооны үйлчилгээ – Үйл
ажиллагаа болон Гэрчилгээжүүлэлт**

Дүрмийн тайлбар

ИНД-171 нь нисэхийн цахилгаан холбооны үйлчилгээ болон байгууламж, тоног төхөөрөмжүүдийн ажиллагааны болон техникийн стандартууд, мөн Хэрэглэлийн нислэгийн дүрмийн нислэг, эсхүл нислэгийн хөдөлгөөний удирдлагад нисэхийн цахилгаан холбооны үйлчилгээ үзүүлж буй байгууллагын гэрчилгээжүүлэлт болон үйл ажиллагааны дүрмүүдийг тогтооно.

Энэхүү дүрэм нь ИНЕГ-ын эрхлэн гаргасан ИНД-171 дүрмийн одоо мөрдөгдөж буй бүрэн хувилбар бөгөөд зөвхөн лавлагааны зориулалттай. Зам, Тээврийн сайдын баталсан дүрмээс хөрвүүлсэн

болно. Зам, Тээврийн сайдын баталсан дүрэм, дүрмийн өөрчлөлтийн хуулбарыг ИНЕГ-аас авах эсвэл www.mcaa.gov.mn веб сайтаас татаж авах боломжтой.

Гарчиг

Бүлэг А — Ерөнхий Зүйл / General

171.1 Зорилго/Purpose.....	6
171.3 Тодорхойлолтууд/Definitions.....	6
171.5 Гэрчилгээнд тавигдах шаардлагууд/Requirement for certificate....	6
171.7 Гэрчилгээжих өргөдөл гаргах нь/Application for certificate.....	7
171.9 Гэрчилгээ олгох/Issue of certificate.....	7
171.11 Гэрчилгээ эзэмшигчийн эрх/Privileges of certificate holder.....	7
171.13 Гэрчилгээний хүчинтэй хугацаа/Duration of certificate.....	8
171.15 Гэрчилгээний хугацаа сунгах/Renewal of certificate.....	8
171.17 Таних тэмдэг болон дуудлага/Identification codes and call signs...8	
171.19 Нисэхийн байгууламжийн мэдээллийг зарлах/Notification of aeronautical facility information.....	9
171.21 Нисэхийн байгууламжийн дамжуулж буй мэдээлэл/Information provided by an aeronautical facility.....	9

Бүлэг В — Гэрчилгээжүүлэлтийн шаардлагууд/Certification Requirements

171.51 Хүний нөөцөд тавигдах шаардлагууд/Personnel requirements.....	9
171.53 Нисэхийн байгууламжид тавигдах шаардлагууд/Aeronautical facility requirements.....	10
171.55 Аюулгүй байдлын хөтөлбөр/Security programme.....	12
171.57 Бичиг баримтжуулалт/Documentation.....	13
171.59 Хуваарьт үзлэг болон шалгалт/Periodic inspection and testing....	13
171.61 Нисэхийн байгууламжийн ажиллагаа/Aeronautical facility performance.....	14
171.63 Үзлэг, хэмжилт болон шалгалтын төхөөрөмж/Inspection, measuring, and test equipment.....	15
171.65 Байгууламжийн мэдээллийг зарлах/Notification of aeronautical facility information.....	16
171.67 Осол, зөрчлийн дараа нисэхийн байгууламжийг шалгах нь/Aeronautical facility check after accident or incident.....	16
171.69 Байгууламжийн гэмтэл, дутагдлын зөрчил/Facility malfunction incidents.....	17
171.71 Бүртгэл/Records.....	17
171.73 Аюулгүй ажиллагааны удирдлага/Safety management.....	18
171.75 Холбооны журмууд/Communication procedures.....	18
171.77 Байгууллагын үйл ажиллагааны заавар/Organisation exposition	19
<u>Бүлэг С — Үйл ажиллагаанд тавигдах шаардлагууд/Operating Requirements</u>	
171.101 Шаардлагад нийцсэн байдлын хадгалалт/Continued compliance.....	21
171.103 Reserved.....	21

171.105 Reserved.....	21
171.107 Ашиглалт, засвар үйлчилгээний зааврууд/Operating and maintenance instructions.....	21
171.109 Дүрмийн шаардлагаас гажих/Deviations.....	22
171.111 Түр ажиллуулах нисэхийн байгууламж/Temporary aeronautical facility	22
171.113 Гэрчилгээ эзэмшигчид тавигдах хязгаарлалтууд/Limitations on certificate holder.....	23
171.115 Гэрчилгээ эзэмшигч байгууллагад өөрчлөлт хийгдэх нь/Changes to certificate holder's organisation.....	23

Бүлэг D — Байгууламжийн техникийн тодорхойлолтууд болон шаардлагууд/Facility Specifications and Requirements

171.201 Нэмэлт техникийн тодорхойлолтууд болон шаардлагууд/Additional Specifications and Requirements.....	25
171.251 Нисэхийн цахилгаан холбооны үйлчилгээний байгууллагын гэрчилгээ эзэмшигч болон өргөдөл гаргагчийн шилжилт/ Transition for aeronautical telecommunication service organisation certificate holders and applicants.....	26
171.253 Нисэхийн цахилгаан холбооны үйлчилгээний байгууллагын гэрчилгээ эзэмшигч болон өргөдөл гаргагчийн шилжилтийн үеийн дотоод чанар баталгаажуулалт/ Transitional internal quality assurance for aeronautical telecommunication service organisation certificate holders and applicants.....	28

А Бүлэг. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

171.1 Зорилго

Энэхүү дүрэм нь дараах стандарт, үйл ажиллагаануудыг зохицуулах зорилготой. Үүнд:

- (1) Нисэхийн цахилгаан холбооны үйлчилгээ болон тоног төхөөрөмж, байгууламжуудын ажиллагаа болон техникийн стандартууд;
- (2) Хэрэглэлийн нислэгийн дүрмийн нислэг эсхүл нислэгийн хөдөлгөөний удирдлагад нисэхийн цахилгаан холбооны үйлчилгээ үзүүлж буй байгууллагын гэрчилгээжүүлэлт болон үйл ажиллагааны дүрмүүд.

171.3 Тодорхойлолт

Үйл ажиллагааны заавар гэдэг нь энэхүү дүрмийн 171.77-гоор шаардагдсан бичиг баримтууд болон.

171.5 Гэрчилгээнд тавигдах шаардлагууд

(a) Нисэхийн цахилгаан холбооны үйлчилгээний гэрчилгээний эрх хэмжээний хүрээ болон түүнд заагдсан нөхцлүүдийн дагуу нисэхийн байгууламжуудыг ажиллуулахаас гадна (b) болон (c)-д зааснаас бусад тохиолдолд ямар ч этгээд нисэхийн цахилгаан холбооны үйлчилгээ үзүүлэх болон нисэхийн байгууламж ажиллуулахыг хориглоно.

(b) Дараах шаардлагууд хангагдсан нөхцөлд нисэхийн радио давтамж дээр ажиллах нисэхийн байгууламжийг ажиллуулах этгээдэд энэ зкүйлийн (a) заалт хамаарахгүй. Үүнд:

- (1) нисэхийн байгууламж, тоног төхөөрөмж нь:
 - (i) радио холбооны дамжуулагч нь нислэгийн хөдөлгөөний үйлчилгээнд оролцохгүй; эсхүл
 - (ii) радио навигацийн байгууламж Хэрэглэлийн нислэгийн дүрмийн нислэг эсхүл нислэгийн хөдөлгөөний үйлчилгээнд ашиглагдахгүй;
- (2) нисэхийн байгууламж, тоног төхөөрөмжийн ажиллагаа нь дараахь шаардлагуудыг хангасан:
 - (i) ICAO Хавсралт 10, Боть III, Хэсэг II, Бүлэг 2 эсхүл Хавсралт 10, Боть I, Бүлэг 3-т заагдсан холбогдох систем, техникийн тодорхойлолтууд; болон

(ii) ICAO Хавсралт 10, Боть II-т заагдсан холбогдох холбооны журмууд;

- (3) Байгууламж, тоног төхөөрөмж нь нисэхийн аливаа нэг цахилгаан холбооны үйлчилгээ эсхүл нисэхийн байгууламж, тоног төхөөрөмжид хөндлөнгийн нөлөөлөл үзүүлэхгүй;
- (4) радио тоног төхөөрөмж нь холбогдох нисэхийн тоног төхөөрөмжийн гэрчилгээ авсан;
- (5) нисэхийн байгууламжийн хувьд 171.17-гийн дагуу таних тэмдэг болон дуудлага олгогдсон.

(c) Дараах шаардлагууд хангагдсан нөхцөлд нисэхийн радио давтамж дээр ажиллах газрын хөдөлгөөнт радио холбооны төхөөрөмжийг ажиллуулах этгээдэд (a) заалт хамаарахгүй. Үүнд:

- (1) радио холбооны тоног төхөөрөмж нь нислэгийн хөдөлгөөний үйлчилгээнд ашиглагдахгүй;
- (2) радио холбооны тоног төхөөрөмж нь ICAO Хавсралт 10, Боть II-т заагдсан холбогдох холбооны журмуудын дагуу ажиллах;
- (3) Радио холбооны тоног төхөөрөмж нь нисэхийн аливаа нэг цахилгаан холбооны үйлчилгээ эсхүл нисэхийн байгууламж, тоног төхөөрөмжид хөндлөнгийн нөлөөлөл үзүүлэхгүй;
- (4) радио тоног төхөөрөмж нь холбогдох радио холбооны тоног төхөөрөмжийн гэрчилгээ авсан.

171.7 Гэрчилгээжих өргөдөл гаргах

Нисэхийн цахилгаан холбооны үйлчилгээний гэрчилгээ эзэмших өргөдөл гаргагч нь дараах материалуудын хамтаар ИНЕГ2471/01 маягтыг бөглөж, ИНЕГ-ын Даргад ирүүлнэ. Үүнд:

- (7.1) Өргөдөл гаргагчийн Үйл ажиллагааны заавар;
- (7.2) Шаардлагатай бол 171.17-д заагдсан таних тэмдэг болон дуудлага хүссэн өргөдөл;
- (7.3) Шаардлагатай бол хуулинд заагдсан зохицуулалтын дагуу өргөдөл гаргаж буй холбогдох төлбөр.

171.9 Гэрчилгээ олгох

ИНЕГ-ын Дарга нь дараахь шаардлагууд хангагдсан гэж үзвэл Хуулийн дагуу нисэхийн цахилгаан холбооны үйлчилгээний байгууллагын гэрчилгээг олгоно. Үүнд:

- (9.1) Өргөдөл гаргагч нь энэ дүрмийн Б бүлгийн шаардлагуудыг хангасан;

(9.2) Өргөдөл гаргагч болон түүний удирдах албан тушаалтнууд нь 171.51(а)(1) болон (2)-т заагдсан шаардлагад нийцсэн;

(9.3) Гэрчилгээ олгосноор иргэний нисэхийн аюулгүй ажиллагаанд сөргөөр нөлөөлөхгүй гэж үзэж байвал.

171.11 Гэрчилгээ эзэмшигчийн эрх

(а) Нисэхийн цахилгаан холбооны үйлчилгээний гэрчилгээнд Хэрэглэлийн нислэгийн дүрмээр үйлдэх нислэгт болон нислэгийн хөдөлгөөний үйлчилгээнд үзүүлэх нисэхийн цахилгаан холбооны үйлчилгээнүүд болон нисэхийн байгууламжуудын төрлүүдийг зааж өгсөн байна.

(b) Гэрчилгээ эзэмшигч нь 171.113-аас хамааран YA3-таа заагдсан нисэхийн цахилгаа холбооны үйлчилгээний дараахь байгууламж, тоног төхөөрөмжүүдийг ажиллуулж болно. Үүнд:

(1) Ажиллуулах нисэхийн нисэхийн байгууламж, тоног төхөөрөмж бүр нь Гэрчилгээ эзэмшигчийн YA3-т тусгагдсан; эсхүл

(2) Тухайн нисэхийн байгууламж, тоног төхөөрөмж нь YA3-т тусгагдаагүй боловч шалгалт, тестийн зорилгоор ажиллуулах түүний ажиллагаа нь 171.53(б)-аар шаардагдаж буй журмын дагуу хянагдаж байгаа бол ажиллуулах боломжтой .

171.13 Гэрчилгээний хүчинтэй хугацаа

(а) Нисэхийн цахилгаан холбооны үйлчилгээний байгууллагын гэрчилгээг 5 жил хүртэл хугацаатайгаар шинээр олгох болон сунгаж болно.

(b) Нисэхийн цахилгаан холбооны үйлчилгээний гэрчилгээ нь хүчинтэй хугацаа дуусах, түр түдгэлзүүлэх, цуцлагдах хүртэл хүчинтэй байна.

(а) Нисэхийн цахилгаан холбооны үйлчилгээний гэрчилгээ эзэмшигч нь хугацаа нь дууссан, эсхүл цуцлагдсан гэрчилгээг ИНЕГ-ын Даргад тэр даруй буцаан шилжүүлнэ.

(b) Түр түдгэлзүүлсэн Нисэхийн цахилгаан холбооны үйлчилгээний гэрчилгээ эзэмшигч нь холбогдох баталгаажуулалт хийлгүүлэхийн тулд ИНЕГ-ын даргад гэрчилгээг тэр даруй өгнө.

171.15 Гэрчилгээний хугацааг сунгах

(а) Нисэхийн цахилгаан холбооны үйлчилгээний байгууллагын Гэрчилгээний хүчинтэй хугацааг сунгуулах хүсэлт гаргахдаа ИНЕГ171/01 маягтыг бөглөж ирүүлнэ.

(b) Гэрчилгээний хүчинтэй хугацааг сунгуулах хүсэлтээ ирүүлэхдээ Гэрчилгээн дээр заагдсан хүчинтэй хугацааг сунгуулах огнооноос

өмнө ирүүлэх болон хэрвээ тодорхой хугацаа заагдаагүй бол Гэрчилгээний хүчинтэй хугацаа дуусах огнооноос 30-аас доошгүй хоногийн өмнө ирүүлнэ.

171.17 Таних тэмдэг болон дуудлага

(a) Аливаа этгээд нь дараах шаардлагуудыг хангаагүй байгууламж, тоног төхөөрөмжүүдийг ажиллуулахыг хориглоно. Үүнд:

(1) ИНЕГ-ын даргаас с) заалтын дагуу олгосон таних тэмдэг хуваарилагдаагүй; эсхүл

(2) 171.5 с) заалтын дагуу ажиллаж байгаагаас бусад тохиолдолд **нисэхийн радио давтамж дээр ажиллаж байгаа радио холбооны** дамжуулагч нь ИНЕГ-ын даргаас с) заалтын дагуу олгосон дуудлага хуваарилагдаагүй бол ажиллуулахыг хориглоно.

(b) Дээр заагдсан таних тэмдэг болон дуудлага хүссэн өргөдөл гаргагч нь ИНЕГ171/02 маягыг бөглөж шаардлагатай бол хуулинд заагдсан зохицуулалтын дагуу өргөдөл гаргаж буй холбогдох төлбөрийн хамтаар ИНЕГ-ын даргад ирүүлнэ.

(c) ИНЕГ-ын дарга нь иргэний нисэхийн аюулгүй ажиллагаанд сөрөг үзүүлэхгүй гэж үзсэн тохиолдолд радио навигацийн байгууламжид таних тэмдэгийг эсхүл радио холбооны тоног төхөөрөмжид дуудлагыг хуваарилан олгож болно.

171.19 Нисэхийн байгууламжийн мэдээллийг зарлан мэдээлэх

Нисэхийн байгууламж, тоног төхөөрөмжийг ажиллуулж буй этгээд нь аль болох боломжит богино хугацаанд байгууламж, тоног төхөөрөмжтэй холбогдолтой мэдээллийн талаар дараах арга хэмжээг авсан байна. Үүнд:

(1) дараах мэдээллийг нисэхийн мэдээллийн үйлчилгээ үзүүлэгч байгууллагад дамжуулсан байна. Үүнд:

(i) Нисэхийн мэдээллийн эмхэтгэл (AIP)-д оруулах шаардлагатай нисэхийн байгууламжийн ажиллагааны талаарх дэлгэрэнгүй мэдээлэл;

(ii) NOTAM мэдээгээр зарлуулах шаардлагатай нисэхийн байгууламжийн ажиллагаанд орсон өөрчлөлтийн талаарх **мэдээллийг дамжуулсан байна.**

(2) Шаардлагатай бол (1)-ийн дагуу дамжуулсан мэдээлэл **нь үнэн зөв хэвлэгдсэн эсэхийг баталгаажуулж хянасан байна.**

(3) ИНД-12-ын дагуу осол, зөрчлийн талаарх мэдээллийг ИНЕГ-ын даргад дамжуулдаг байна.

171.21 Нисэхийн байгууламжийн дамжуулж буй мэдээлэл

Аливаа нисэхийн байгууламж, тоног төхөөрөмжийг ажиллуулж байгаа этгээд нь тухайн байгууламжийн дамжуулж байгаа мэдээлэл алдаатай байна гэж үзэж байгаа бол, эсхүл алдаатай мэдээлэл дамжуулж байж магадгүй гэсэн ямар нэгэн шалтгаантай байгаа бол тухайн байгууламжийг үргэлжлүүлэн ажиллуулахыг хориглоно.

В Бүлэг. Гэрчилгээжүүлэлтийн шаардлагууд

171.51 Хүний нөөцөд тавигдах шаардлагууд

(а) Нисэхийн цахилгаан холбооны үйлчилгээний гэрчилгээ хүссэн өргөдөл гаргагч нь дараах албан тушаалтан, ажилтнуудтай байна. Үүнд:

1) гүйцэтгэх захирал хэлбэрээр тодорхойлогдсон албан тушаалтан нь:

(i) үйл ажиллагаанд тавигдаж буй шаардлагуудыг хангахад чиглэгдсэн бүхий л арга хэмжээнүүдийг авах болон тэдгээрт шаардлагатай санхүүгийн захиран зарцуулах эрх мэдэлтэй байх;

(ii) байгууллага нь энэхүү дүрэмд заагдсан стандарт, шаардлагуудыг хангаж байгааг харицах;

(2) гүйцэтгэх захиралд шууд захирагдах бөгөөд дараах үүрэг хариуцлага бүхий удирдах албан тушаалтнууд—

(1.i) өргөдөл гаргагчийн байгууллага нь үйл ажиллагааны заавартаа нийцэж байгааг бататгах;

(1.ii) энэхүү дүрмийн 171.73-д заагдсан аюулгүй ажиллагааны удирдлагад зориулагдсан тогтолцоог хариуцах;

(3) өргөдөл гаргагчийн үйл ажиллагааны зааварт заагдсан байгууламжуудыг шалгах, хянах болон ашиглалт үйлчилгээг хийж гүйцэтгэх хангалттай тооны ажилтнуудтай байна.

(аа) (а)(2)(ii) заалтаар шаардагдаж буй удирдах ажилтан, эсхүл удирдах ажилтнууд нь аюулгүй ажиллагааны тогтолцоо болон гэрчилгээ эзэмшигчийн үйл ажиллагааг удирдах дадлага туршлага, ур чадвартайгаа батлан харуулсан байна.

(b) Нисэхийн цахилгаан холбооны үйлчилгээний гэрчилгээний өргөдөл гаргагч нь Гэрчилгээ эзэмшигчээс Үйл ажиллагааны зааварт тусгагдсан байгууламжуудыг ажиллуулах эрх олгогдсон ажилтнуудад зориулан дараах ажиллагааг багтаасан журам гаргасан байна. Үүнд:

- (1) Тэдгээр ажилтнуудын ур чадварыг үнэлэх;
 - (2) Эрх олгогдсон ажилтнуудын ур чадварыг хадгалах;
- (1) Тэдгээр ажилтнуудад Эрх олгогдсон хүрээг нотолгоо болгон бичгээр гаргаж өгөх ажиллагаа.

171.53 Нисэхийн байгууламжид тавигдах шаардлагууд

(а) Нисэхийн цахилгаан холбооны үйлчилгээний гэрчилгээ хүссэн өргөдөл гаргагч нь дараах шаардлагыг хангахуйц баталгаажуулсан журмыг тогтоосон байна:

- (1) үйл ажиллагааны зааварт тусгагдсан байгууламж бүр нь:
 - (a.i) тухайн байгууламжид хамаарах техникийн тодорхойлолтыг хангахуйц маяг, загвартай байх болон суурилуулагдсан;
 - (a.ii) ИКАО Хавсралт 10-ын 1, 2, 4-р ботид заагдсан систем тодорхойлолтууд болон техникийн үзүүлэлтийн стандартуудыг хангасан;
 - (a.iii) D бүлгийн хамааралтай үзүүлэлтүүд болон шаардлагуудыг хангасан;
 - (a.iv) 171.17-гийн дагуу таних тэмдэг эсхүл дуудлага шаардагдсан тохиолдолд таних тэмдэг, дуудлага олгогдсон;
- (2) Дараах байгууллагуудын үйл ажиллагааны шаардлагуудыг хангах үүднээс Аэродром дээр ойртолт, буулт үйлдэх болон хөөрөлт үйлдэхэд зайлшгүй ашиглагддаг, өргөдөл гаргагчийн үйл ажиллагааны зааварт заагдсан байгууламж бүрийн ажиллагааны мэдээллээр хангадаг байна. Үүнд:
 - (1.i.i) Аливаа аэродром дээр аэродромын үйчилгээг үзүүлж байгаа үед тухайн аэродром дээр аэродромын удирдлагын үйлчилгээ үзүүлж буй нислэгийн хөдөлгөөний удирдлагын нэгжид;
 - (1.i.ii) Аливаа аэродром дээр ойртолтын үйчилгээг үзүүлж байгаа үед тухайн аэродром дээр ойртолтын удирдлагын үйлчилгээ үзүүлж буй нислэгийн хөдөлгөөний удирдлагын нэгжид;
- (3) Өргөдөл гаргагчийн үйл ажиллагааны зааварт тусгагдсан нисэхийн байгууламж тус бүр нь үйлчилгээ үзүүлж буй нислэгийн хөдөлгөөний үйлчилгээ эсхүл радио навигацийн үйлчилгээний тасралтгүй, найдвартай байдлыг хангахуйц цахилгаан тэжээлийн эх үүсвэртэйгээр суурилуулагдсан;

(4) Өргөдөл гаргагчийн үйл ажиллагааны зааварт тусгагдсан нисэхийн байгууламж тус бүр нь тухайн байгууламжийг эвдлэх, сүйтгэх эсхүл гаднаас нөлөөлөх аливаа эрсдлийг хамгийн бага түвшинд байлгах зорилгоор 171.55-аар шаардагдсан аюулгүй байдлын хөтөлбөрийн дагуу суурилуулагдсан;

(5) Өргөдөл гаргагчийн үйл ажиллагааны зааварт тусгагдсан аливаа нисэхийн байгууламжийн аливаа эрсдэлтэй бүс нь:

(1.i) Тухайн нисэхийн байгууламжийн байршлын зураглалд тодорхой тусгагдсан;

(1.ii) Газар дээрээ тохирох тэмдэглэгээгээр хамгаалагдсан;

(1.iii) Байрлалын хязгаарлалтууд нь барилга байгууламж, хашаа, тээврийн хэрэгсэл, газрын үйлчилгээний бусад тоноглол хэрэгсэл, эсхүл агаарын хөлгөөр зөрчигдөхгүй байх үүднээс газрын эзэмшигч, аэрдоромын үйлчилгээ үзүүлэгч, нислэгийн хөдөлгөөний удирдлагын нэгж зэргээс зохих байгууллагатай нь бичгээр гэрээ байгуулж хамгаалсан байна.

(b) Нисэхийн цахилгаан холбооны үйлчилгээний өргөдөл гаргагч нь газар дээрх шалгалт туршилтын зорилгоор нисэхийн байгууламжийг түр ажиллуулах бол энэхүү шалгалт туршилтыг хийж гүйцэтгэх журам гаргасан байна.

(c) (b)-гээр шаардагдаж буй журам нь дараах шаардлагуудыг агуулсан байна. Үүнд:

(1) Түр ажиллуулах байгууламжийн ажиллагаа нь үйл ажиллагаанд ашиглагдаж буй нисэхийн байгууламжуудад ямар нэгэн нөлөөлөл үзүүлэхгүй байх;

(2) Түр ажиллуулах байгууламжийн ажиллагааны талаарх шаардлагатай мэдээлэл нь NOTAM-аар зарлуулах болон шаардлагатай бол AIP-ын нэмэлтээр хэвлүүлэх үүднээс Нисэхийн мэдээлийн үйлчилгээний байгууллагад дамжуулагдсан байх;

(3) Тохирох NOTAM хэвлэгдсэн байна.

171.55 Аюулгүй байдлын хөтөлбөр

(a) Нисэхийн цахилгаан холбооны үйлчилгээний өргөдөл гаргагч нь Үйл ажиллагааны зааварт тусгагдсан байгууламжууддаа аюулгүй байдлын хөтөлбөр боловсруулсан байна.

(b) Нисэхийн цахилгаан холбооны үйлчилгээний гэрчилгээний эрх хэмжээний хүрээнд ажиллуулах аливаа нисэхийн байгууламжийг эвдлэх,

сүйтгэх эсхүл гаднаас нөлөөлөх нь агаарын хөлгийн аюулгүй ажиллагаанд аюул учруулахаар бол (а)-гаар шаардагдаж буй аюулгүй байдлын хөтөлбөр нь тухайн эвдлэх, сүйтгэх эсхүл гаднаас нөлөөлөх эрсдлийг хамгийн бага хэмжээнд байлгахын тулд мөрдөгдөх аюулгүй байдлын бодит шаардлагууд, аргачлал болон журмуудыг тодорхойлсон байна.

(с) (а) заалтаар шаардагдаж буй аюулгүй байдлын хөтөлбөр нь дараах тохиолдлуудад шаардагдаж болох аюулгүй байдлын шаардлага, аргачлал болон журмуудыг агуулсан байна. Үүнд:

(1) Зөвшөөрөлгүй нэвтрэхээс урьдчилан сэргийлэх үүднээс ямар ч тохиолдолд нисэхийн байгууламж бүрийн нэвтрэх хяналт зөв хэлбэртэй байгааг бататгах;

(2) Нисэхийн байгууламжийг дэлбэлэхээр заналхийлэх эсхүл сүйтгэх өөр хэлбэрээр залхийлэх тохиолдолд ажилчдын мөрдөх;

(3) Аливаа нэвтрэх тохиолдол болон нөлөөллийг тэр даруй илрүүлэхийн тулд байнга хүн байдаггүй өрөө тасалгааг хяналтанд байлгах.

(d) (а)-д заагдсан аюулгүй байдлын хөтөлбөр нь ИНД12-ын дагуу аюулгүй байдлын зөрчлийг мэдээлэх, шинжлэн шалгах болон тайлагнах журамтай байна.

171.57 Бичиг баримтжуулалт

(а) Нисэхийн цахилгаан холбооны үйлчилгээний гэрчилгээний Өргөдөл гаргагч нь Үйл ажиллагааны заавартаа тусгасан байгууламжуудын ажиллагаанд шаардлагатай техникийн баримт бичиг, ашиглалтын болон, засвар үйлчилгээний заавар, техникийн стандартууд, холбогдох бусад бичиг баримттай байна.

(b) Нисэхийн цахилгаан холбооны үйлчилгээний гэрчилгээний Өргөдөл гаргагч нь энэ зүйлийн (а)-д заагдсан болон холбогдох бусад дүрмийн заалтуудаар шаардагдсан бичиг баримтуудыг хянах журамтай байна.

(с) (b)-д заагдсан журам нь дараах шаардлагуудыг хангасан байна:

(1) бүх бичиг баримтыг ашиглахаас өмнө 171.51-д заагдсан эрх бүхий албан тушаалтан хянаж, баталгаажуулсан байх;

(2) байгууламжийн ажиллагаа, ашиглалтанд шаардлагатай холбогдох бичиг баримтын хянаж, зөвшөөрөгдсөн хүчин төгөлдөр хувийг тухайн ажлын байранд ажиллах хүмүүс авч бүрэн ашиглах боломжтой байх;

(3) хүчингүй болсон бичиг баримтыг ажлын байр болон хэрэгцээнээс нэн даруй гаргаж мөрдүүлэхгүй байх;

(4) бичиг баримтад оруулж байгаа нэмэлт өөрчлөлтүүдийг энэ дүрмийн 171.51 зүйлд заасан эрх бүхий албан тушаалтан хянаж, баталгаажуулдаг байх ;

(5) бичиг баримтуудын хүчин төгөлдөр хувийг тодорхойлох боломжтой байх.

171.59 Хуваарьт үзлэг болон шалгалт

Нисэхийн цахилгаан холбооны үйлчилгээний гэрчилгээний Өргөдөл гаргагч нь Үйл ажиллагааны зааварт заагдсан байгууламжуудын хэвийн ажиллагааны зохих шаардлага, техникийн үзүүлэлтүүдийг хангаж буйг бататгах, хуваарьт техникийн үзлэг, шалгалт хийх ажлыг зохицуулсан журамтай байна.

(a) (a)-д заагдсан журам нь дараах зүйлийг агуулсан байна:

(1) байгууламжийн газрын үзлэг, шалгалт болон шаардлагатай бол хийгдэх нислэгээр гүйцэтгэх шалгалт; болон

(2) нисэхийн байгууламжид дараах мэдээллүүдийг үндэслэн гүйцэтгэх хуваарьт үзлэг, шалгалтын давтамжийг тогтоох, өөрчлөх шалгуурууд:

(2.i) ICAO-гоос гаргасан холбогдох мэдээлэл;

(2.ii) тухайн байгууламжийн найдвартай ажиллагааны холбогдох өгөгдөлүүд;

(2.iii) тухайн байгууламжийн эсхүл ижил төрлийн байгууламжийн найдвартай ажиллагааны шалгагдсан мэдээлэл, тухайн байгууламжийн ажиллах орчны тогтвортой байдал;

(3) Үйл ажиллагааны зааварт заагдсан нисэхийн байгууламж бүрийн хуваарьт үзлэг, шалгалтын давтамжийг тогтоох болон өөрчлөх үндэслэлийг баримтжуулсан байх.

(b) Нисэхийн цахилгаан холбооны үйлчилгээний гэрчилгээний өргөдөл гаргагч нь дараах хөтөлбөрүүдийг боловсруулсан байна:

(1) Өрөгдөл гаргагчийн үйл ажиллагааны зааварт тусгагдсан байгууламж бүрт хийх хуваарьт үзлэгийн хөтөлбөр;

(2) үйл ажиллагааны зааварт заагдсан байгууламж бүрт тогтмол хуваарийн дагуу хийгдэх шалгалтын хөтөлбөр;

(3) агаарын навигацийн аюулгүй ажиллагаанд нөлөөлөхгүйгээр нисэхийн байгууламжийн хугацаат шалгалтын нислэгийг (b)(2) зүйлийн дагуу газрын хугацаат үзлэг, шалгалтаар орлуулах боломжтойг тогтоосноос бусдаар үйл ажиллагааны зааварт заагдсан байгууламж бүрээр гаргасан хугацаат шалгалтын нислэгийн хөтөлбөр.

(c) Энэ зүйлийн (c)-гийн 2/ болон 3/-т дурьдсан хөтөлбөр нь энэ зүйлийн (b)-гийн 2/-т заасан шалгуурт үндэслэх бөгөөд нисэхийн байгууламж бүрийн шалгалт хоорондын хамгийн их хугацааг тодорхойлсон байна.

(d) Нисэхийн цахилгаан холбооны үйлчилгээний гэрчилгээний Өргөдөл гаргагч нь ИНЕГ-ын даргад хуваарьт Шалгалтын нислэг хийх шаардлагагүй радио навигацийн төхөөрөмжийн талаар мэдэгдэнэ.

171.61 Нисэхийн байгууламжийн ажиллагаа

Нисэхийн цахилгаан холбооны үйлчилгээний гэрчилгээний Өргөдөл гаргагч нь дараах шаардлагыг хангаагүй нөхцөлд Үйл ажиллагааны заавартаа заагдсан нисэхийн байгууламжуудыг ажиллуулахгүй бөгөөд энэ талаар мөрдөх журмыг боловсруулан гаргасан байна:

(61.1) Нисэхийн байгууламжийг ажиллуулах этгээд нь зохих зөвшөөрөлтэй, энэ дүрмийн 171.51–ийн (b)-д заасны дагуу ур чадвараа үнэлүүлсэн байх;

(61.2) энэ дүрмийн 171.107-р зүйлээр шаардагдсан техник ашиглалтын болон засвар үйлчилгээний зааврын дагуу нисэхийн байгууламжийн ажиллагааг бататгах техникийн үзлэг, шалгалтыг хийсэн байх;

(61.3) байгууламжийн талаарх мэдээллийн бүртгэл нь энэ дүрмийн 171.71 зүйлд заасан журмын дагуу хийгдсэн байх.

171.63 Үзлэг, хэмжилт болон шалгалтын төхөөрөмж

(a) Нисэхийн цахилгаан холбооны үйлчилгээний гэрчилгээний өргөдөл гаргагч нь Үйл ажиллагааны заавартаа заагдсан байгууламж бүрийн ашиглалт, үйлчилгээг хариуцах инженер, техникийн ажилтнууд нь шаардлагатай үзлэг, хэмжилт болон шалгалтын төхөөрөмжүүдээр хангагдсан байхыг бататгана.

(b) Нисэхийн цахилгаан холбооны үйлчилгээний гэрчигээний Өргөдөл гаргагч нь хэмжилт, шалгалтыг гүйцэтгэхэд шаардлагатай төхөөрөмжийн нарийвчлалыг баталгаажуулах зорилгоор энэ зүйлийн (a)-д заагдсан бүх үзлэг, хэмжилт болон шалгалтад ашиглагдах төхөөрөмжүүдийн хяналт, тохируулга болон ашиглалтын үйл ажиллагааг тусгасан журмыг боловсруулж мөрдөнө.

(c) Энэ зүйлийн (б)-д заасан журмаар байгууламжийн ажиллагааны чухал өгөгдлүүдийг хэмжих төхөөрөмжүүд нь дараах шаардлагыг хангасан байна:

(1) ашиглахаас өмнө эсхүл тогтмол хуваарийн дагуу зохих үндэсний стандартад нийцүүлэн тохируулга хийгдсэн байна; болон

(2) шалгах төхөөрөмж бүр өөрийн тохируулгыг үзүүлэх индикатортай байх;

(3) дараах хяналтууд байнга тавигдаж байна:

(3.i) тохируулгыг нь алдагдуулахгүй байхаар хамгаалан, тоногдсон байх;

(3.ii) ашиглах, зөөх, хадгалж хамгаалах явцад нарийвчлал болон тохиргоо нь хадгалагдаж байх.

(d) Хэрвээ нисэхийн байгууламжийн ажиллагааг шалгахад техник хангамж болон програм хангамжууд ашиглагдаж байгаа бол (b) зүйлд заагдсан журам нь байгууламжийн ажиллагааны мэдээллийг үнэн зөвөөр тодорхойлох боломжтой байгааг бататгах үүднээс энэхүү шалгалтын системүүдийг дараах хугацаануудад заавал шалгадаг байхыг шаардсан байна:

(1) Ашиглалтанд хүлээн авахаас өмнө;

(2) Тогтоогдсон хуваарийн дагуу.

171.65 Байгууламжийн мэдээллийг зарлах

(a) Нисэхийн цахилгаан холбооны үйлчилгээний Өргөдөл гаргагч нь Үйл ажиллагааны заавартаа заагдсан байгууламж бүр нь 171.19-д заагдсан шаардлагуудыг хангаж байгааг бататгах журамтай байна.

(b) (a) зүйлээр шаардагдсан журам нь дараах ажиллагаануудыг агуулсан байна. Үүнд:

(1) Нисэхийн байгууламжийн ажиллагааны талаар Нисэхийн мэдээллийн үйлчилгээний байгууллагад мэдээлсэн мэдээлэл нь Нисэхийн мэдээллийн эмхэтгэл(AIP)-д алдаагүй хэвлэгдсэн байх;

(2) агаарын навигацийн үйлчилгээний байгууламжийн ажиллагааны аливаа өөрчлөлтийн талаарх мэдээллийг NOTAM мэдээгээр зарлуулсан байх.

171.67 Осол, зөрчлийн дараа нисэхийн байгууламжийг шалгах нь

(a) Нисэхийн цахилгаан холбооны үйлчилгээний гэрчилгээний Өргөдөл гаргагч нь осол, зөрчилд өртсөн агаарын хөлөг ашиглаж байсан, эсхүл тухайн үед нислэгийн хөдөлгөөний үйлчилгээнд ашиглагдаж байсан нисэхийн байгууламжийн ажиллагааны байдлыг шалгах, үнэн зөв бүртгэлийг хийх журамтай байна.

(b) (a) зүйлээр шаардагдсан журам нь дараах шаардлагуудыг тусгасан байна:

(1) Осол, зөрчилтэй холбогдолтой Нисэхийн цахилгаан холбооны үйлчилгээний гэрчилгээ эзэмшигчид мэдэгдсэний дараа байгууламжийн ажиллагааны төлөвийг тэр даруй шалгах;

(2) дээрх байгууламжийн ажиллагааны шалгалтын бүртгэл, тайлан болон өмнөх ажиллагааны талаарх бүртгэлийг цаашдын осол, зөрчлийг шинжлэн шалгах үйл ажиллагаанд хэрэглэх боломжтойгоор аюулгүй байдлыг хангаж хадгалах;

(3) (b)(2)-оор шаардагдсан бүртгэл, тайланг хамгийн сүүлд нэмэлт оруулснаас хойш 3 жил хадгалах.

171.69 Байгууламжийн гэмтэл, дутагдлын зөрчил

Нисэхийн цахилгаан холбооны үйлчилгээний гэрчилгээний өргөдөл гаргагч нь дараах журамтай байна. Үүнд:

(69.1) ИНД12-ын шаардлагын дагуу байгууламжийн гэмтэл, дутагдлын зөрчлийн талаар мэдээлэх, үзлэг шалгалт хийх болон тайлагнах;

(69.2) Байгууламжийн гэмтэл, дутагдлын зөрчлийн шалтгааныг арилгах болон давтан гарахаас сэргийлэх үүднээс залруулах арга хэмжээний төлөвлөгөө гаргаж, хэрэгжүүлдэг байх.

171.71 Бүртгэл

(a) Нисэхийн цахилгаан холбооны үйлчилгээний гэрчилгээний Өргөдөл гаргагч нь дараах баримтуудад шаардлагатай бүртгэлүүдийг ангилах, цуглуулах, индексжүүлэх, хадгалах, хөтлөх болон устгах үйл ажиллагаануудыг тусгасан журамтай байна:

(1) Нисэхийн цахилгаан холбооны үйлчилгээний найдвартай хангалт;

(2) Үйл ажиллагааны зааварт заагдсан байгууламж бүрийн аюулгүй, найдвартай ажиллагаа.

(b) (a) зүйлээр шаардагдсан журмуудаар дараах үнэн зөв бүртгэлүүд шаардагдсан байна:

(1) Нисэхийн байгууламж тус бүрээр хөтлөгдөх баримтуудын бүртгэл:

(1.i) Нисэхийн байгууламжийн ажиллагааны байдлыг баримтжуулсан хэлбэрээр;

(1.ii) Бүртгэгдэж буй ажиллагаа тус бүрээр хариуцсан ажилтан эсхүл ажилтнуудад хянах боломж бүхий байгууламжийн ашиглалт, хуваарьт үзлэг, шалгалтын түүхийг харуулсан байх;

(2) энэ дүрмийн 171.59(a) зүйлд заасны дагуу нисэхийн байгууламж бүрийн хугацаат шалгалт тохируулгын гүйцэтгэл болон өөрчлөлтийн баримтжуулсан бүртгэл;

(3) энэ дүрмийн 171.63(a) зүйлд заасан нисэхийн байгууламжийн үндсэн өгөгдлүүдийг шалгах шалгалт тохируулга, хэмжилтийн төхөөрөмжийн байршил, техник үйлчилгээ болон тохируулгын талаарх хянах боломж бүхий түүхийн мэдээллийг агуулсан баримтын бүртгэл;

(4) ИНД12-ын дагуу мэдээлсэн байгууламжийн гэмтэл, дутагдлын зөрчил тус бүрээр дараах мэдээллийг агуулсан баримтын бүртгэл:

(4.i) Гэмтэл, дутагдлын шинж тэмдэгийн дэлгэрэнгүй мэдээлэл;

(4.ii) Шалгалтаар илэрсэн дутагдал, зөрчлүүд;

(4.iii) Цаашид авах залруулах арга хэмжээ;

(4.iv) Хэрвээ боломжтой бол эрх бүхий байгууллагад ИНД12-ын дагуу илгээсэн тайлангийн хуулбар;

(5) [түдгэлзүүлсэн]

(6) энэ дүрмийн 171.51(б) зүйлд заасан, нисэхийн байгууламжийг ажиллуулах эрх олгогдсон этгээдийн дадлага туршлага, мэргэшил, сургалт, ур чадвар, түүнд олгогдсон эрхийн талаарх нарийвчилсан мэдээллийг тусгасан баримтын бүртгэл.

(c) (a) зүйлээр шаардагдсан журам нь дараах шаардлагуудыг тусгасан байна. Үүнд:

(1) Бүх бүртгэл цэвэр гаргацтай, албан хэргийн тогтсон хэлбэрээр хөтлөгдсөн байх;

(2) **(b)(1) зүйлээр шаардагдсан нисэхийн бүх байгууламжийн** баримтуудын бүртгэлүүд нь дараах нэмэлт шаардлагууд тавигдахаас бусад тохиолдолд 3-аас доошгүй жил хадгалагдана:

(a.i) ИНЕГ-ын Дарга шаардсан; эсхүл

(a.ii) Нисэхийн байгууламжийн ажиллагааны талаарх түүхийг үүсгэх.

171.73 Аюулгүй ажиллагааны удирдлага

Нисэхийн цахилгаан холбооны үйлчилгээний гэрчилгээний өргөдөл гаргагч нь ИНД100.3-ын дагуу аюулгүй ажиллагааны удирдлагын тогтолцоог бий болгож, нэвтрүүлж, хэрэгжүүлж ажилладаг байна.

171.75 Холбооны журмууд

Нисэхийн цахилгаан холбооны үйлчилгээний Өргөдөл гаргагч нь Үйл ажиллагааны заавартаа заагдсан байгууламжуудын ашиглалтын журам, зааврууд нь Чикагогийн конвенцийн Хавсралт 10-ын II-р ботид тодорхойлсон холбооны холбогдох журмуудад заасан шаардлагуудтай нийцэж байгааг бататгасан байна.

171.77 Байгууллагын үйл ажиллагааны заавар

(a) Нисэхийн цахилгаан холбооны үйлчилгээний гэрчилгээний өргөдөл гаргагч нь дараах мэдээллийг агуулсан Үйл ажиллагааны зааврыг ИНЕГ-ын даргад ирүүлнэ:

(1) Өргөдөл гаргагч байгууллагын өмнөөс дараахыг бататган гаргасан гүйцэтгэх захирлын мэдэгдэл:

(1.i) Үйл ажиллагааны заавар нь байгууллагыг тодорхойлж байгаа бөгөөд энэхүү дүрмийн шаардлагуудыг байнга хангаж ажиллах хэрэгсэл, аргачлалаа харуулж байгаа;

(1.ii) Байгууллагын ажилтнууд нь Үйл ажиллагааны заавар болон холбогдох бүх гарын авлагууд, ашиглалт, үйлчилгээний зааварчилгаануудыг үргэлж дагаж мөрдөх;

(1A) 171.73 зүйлээр шаардагдсан аюулгүй ажиллагааны удирдлагын тогтолцооны хувьд:

(i) 100.3(b) зүйлээр шаардагдсан бүх бичииг баримтууд;

(ii) Нисэхийн цахилгаан холбооны үйлчилгээний гэрчилгээний хүчинтэй хугацаагаа сунгуулахаас бусад өргөдөл гаргагчийн хувьд аюулгүй ажиллагааны удирдлагын

тогтолцоог хэрхэн нэвтрүүлэхээ тодорхойлон харуулсан
Нэвтрүүлэх төлөвлөгөө;

(2) Энэ дүрмийн 171.51.(а) 1/ болон 2/-т заасан албан
тушаалтнуудын нэрс, албан тушаал;

(3) Энэ дүрмийн 171.51.(а) 1/ болон 2/-т заасан албан
тушаалтнуудын Дараах заалтуудыг агуулсан үүрэг хариуцлагууд:

(3.i) Байгууллагын нэрийн өмнөөс Даргатай эсхүл Удирдах
байгууллагатай ямар асуудлуудаар шууд хариуцлага хүлээх;

(3.ii) Аюулгүй ажиллагааны удирдлагад хүлээх үүрэг
хариуцлага;

(4) 171.51.(а) 1/ болон 2/-т заасан албан тушаалтнуудын (а)(7)
зүйлд заагдсан байршил бүрийг хамарсан үүрэг хариуцлагыг
харуулсан бүтэц, зохион байгуулалтын бүдүүвч;

(5) (а)(7) зүйлд заагдсан байршлуудаар харуулсан байгууллагын
боловсон хүчний бүтэц зохион байгуулалтын бүдүүвч; болон
(5А) байгууллагын дотоод аюулгүй ажиллагааны үүрэг
хариуцлагын бүдүүвчийг харуулсан мэдээлэл;

(6) Нисэхийн цахилгаан холбооны үйлчилгээний гэрчилгээний
хүрээнд олгогдсон эрхийн дагуу ажиллуулах нисэхийн
байгууламжуудын төрлийн жагсаалт;

(7) Байгууллагын ИТА-д төвлөрсөн бөгөөд (а)(6) зүйлийн дагуу
бэлтгэгдсэн нисэхийн байгууламжуудын төрлүүдийг хангаж эсхүл
ажиллуулж байгаа байршил бүрийн үйл ажиллагааны хүрээ;

(8) (а)(7) зүйлд заагдсан байршил бүрт ажиллуулж буй нисэхийн
байгууламж бүрийн ажиллагааны дэлгэрэнгүй мэдээлэл;

(9) 171.55 зүйлээр шаардагдсан аюулгүй байдлын хөтөлбөрийн
дэлгэрэнгүй мэдээлэл;

(10) [түдгэлзүүлсэн]

(11) Дараах шаардлагуудын дагуу боловсруулан гаргасан журмууд,
эсхүл холбогдох журмуудыг багтаан тодорхойлон харуулсан
баримт бичгүүдийг агуулсан журмуудын тайлбар:

(11.i) Ажилтнуудын ур чадвартай хролбогдолтой 171.51(b)

(1) болон (2) зүйлүүд;

(11.ii) Байгууламжуудын төлөвлөлт, суурилуулалт, хүлээн
авах ажиллагаатай холбогдолтой 171.53(a) зүйл;

(11.iii) Туршилт, шалгалтаар түр ажиллуулах байгууламжтай
холбогдолтой 171.53(b) зүйл;

(11.iv) Бичиг баримтын хяналттай холбогдолтой 171.57(b)
зүйл;

(11.v) Байгууламжуудын хуваарьт үзлэг, шалгалттай
холбогдолтой 171.59(a) зүйл;

(11.vi) Байгууламжийн ажиллагаатай холбогдолтой 171.61
зүйл;

(11.vii) Үзлэг, хэмжилт болон шалгалтын төхөөрөмжийн
хяналт, тохиргоо, ашиглалттай холбогдолтой 171.63 зүйл;

(11.viii) Байгууламжийн мэдээллийг зарлахтай холбогдолтой 171.65(a) зүйл;

(11.ix) Осол, зөрчилийг мэдээлсний дараа байгууламжийн ажиллагааг шалгахтай холбогдолтой 171.67(a) зүйл;

(11.x) Байгууламжийн гэмтэл, дутагдлын зөрчилтэй холбогдолтой 171.69;

(11.xi) Бүртгэл бүхий баримтуудыг ангилах, цуглуулах, индексжүүлэх, хадгалах, хөтлөх болон устгах үйл ажиллагаануудтай холбогдолтой 171.71(a) зүйл;

(11.xii) Холбооны журмуудтай холбогдолтой 171.75 зүйл;

(12) Үйл ажиллагааны зааврыг хянах, өөрчлөх болон түгээх талаарх журам.

(b) Өргөдөл гаргагчийн Үйл ажиллагааны заавар нь Даргад хүлээн зөвшөөрөгдөхүйц байна.

С Бүлэг. Үйл ажиллагаанд тавигдах шаардлагууд

171.101 Шаардлагад нийцсэн байдлын хадгалалт

Нисэхийн цахилгаан холбооны үйлчилгээний гэрчилгээ эзэмшигч нь дараахь шаардлагуудыг хангаж ажиллана. Үүнд:

(1) Энэхүү дүрмийн Б бүлэгт заагдсан гэрчилгээжүүлэлтийн шаардлагууд болон стандартуудыг байнга хангаж ажиллах;

(2) Үйл ажиллагааны зааварт тусгагдсан журмуудыг мөрдөж ажиллах;

(3) **Удирдах ажилтан бүхий Үйл ажиллагааны зааварт заагдсан** байршил бүрт үйл ажиллагааны зааврын хүчин төгөлдөр, иж бүрэн нэгээс доошгүй хувийг байршуулсан байх;

(4) Ажилтнууд нь ажил үүргээ гүйцэтгэхэд шаардагдах үйл ажиллагааны зааврын хамааралтай хэсгүүдийг ашиглахад бэлэн байхаар байршуулсан байх;

(5) Байгууллагын хаяг, утасны дугаар, факсын дугаар өөрчлөгдөх тохиолдолд энэ тухайгаа ИНЕГ 24171/01 маягтаар Даргад 28 хоногийн дотор мэдэгдсэн байна.

171.103 Reserved

171.105 Reserved

171.107 Ашиглалт, засвар үйлчилгээний зааврууд

(a) Нисэхийн цахилгаан холбооны гэрчилгээ эзэмшигч нь дараахь шаардлагуудыг мөрдөж ажиллана. Үүнд:

- (1) Үйл ажиллагааны заавартаа заагдсан байгууламж бүрийг ашиглах, засвар үйлчилгээ хийхэд тавигдах шаардлагуудыг тусгасан ашиглалт, засвар үйлчилгээний заавруудтай байна;
- (2) Ашиглах, зааварчилга авах зориулалтаар ажилтнуудыг (1)-д заагдсан ашиглалт, засвар үйлчилгээний заавруудаар хангасан байна.

(b) (a)(1) зүйлээр шаардагдсан ашиглалт, засвар үйлчилгээний зааврууд нь даарх зүйлсийг агуулсан байна:

- (1) Нисэхийн байгууламж бүрийн ажиллагааны чухал үзүүлэлтүүдийн дэлгэрэнгүй мэдээлэл;
- (2) (b)(1)-д заагдсан ажиллагааны чухал үзүүлэлтүүдийн холбогдох хамгийн бага төвшингүүд;
- (3) (b)(1)-д заагдсан ажиллагааны чухал үзүүлэлтүүдийг хэмжихэд шаардлагатай шалгалтын төхөөрөмжүүдийн талаарх дэлгэрэнгүй заавар;
- (4) Ашиглалтын үед заавал хийгдэх үзлэг, шалгалтын талаарх дэлгэрэнгүй заавар;
- (5) Нисэхийн байгууламж тус бүрээр засвар үйлчилгээний үед заавал хийгдэх үзлэг, шалгалтын талаарх дэлгэрэнгүй заавар.

171.109 Дүрмийн шаардлагаас гажих

(a) Нисэхийн цахилгаан холбооны үйлчилгээний Гэрчилгээ эзэмшигч нь нислэг үйлдэж байгаа агаарын хөлөг, зорчигчдын амь нас, эд хөрөнгийг хамгаалах шуурхай арга хэмжээ авах шаардлага тулгарсан тохиолдолд энэ дүрмийн аливаа шаардлагаас энэ дүрмийн 171.113 (a)-д заасан хүрээнд гажиж болно.

(b) Энэ зүйлийн (a)-д зааснаар Гэрчилгээ эзэмшигч нь дүрмээс гажсан тохиолдолд дараах арга хэмжээг авна:

- (1) Даргад дүрмийн шаардлагаас гажиж, шуурхай арга хэмжээг авсан тухай тайланг 14 хоногийн дотор бичгээр гаргах;
- (2) Энэ зүйлийн (б) 1-д заасан тайланд дүрмийн шаардлагаас гажих шалтгаан, үргэлжилсэн хугацаа, сунгалт зэргийг нарийвчлан тайлбарласан байна.

171.111 Түр ажиллуулах нисэхийн байгууламж

Нисэхийн цахилгаан холбооны үйлчилгээний гэрчилгээ эзэмшигч нь газар дээрх туршилтын зорилгоор байгууламжийг түр ажиллуулахаар бол 171.53(b) болон (c) зүйлүүдээс бусад энэхүү дүрмийн Б бүлгийн шаардлагуудыг мөрдөхгүй байж болно.

171.113 Гэрчилгээ эзэмшигчид тавигдах хязгаарлалтууд

(a) Газар дээрх шалгалт, хэмжилтийн зорилгоор нисэхийн байгууламжийг 171.53(b) зүйлд заасны дагуу түр ажиллуулахаас бусад тохиолдолд нисэхийн цахилгаан холбооны үйлчилгээний гэрчилгээ эзэмшигч нь байгууламжийн гаргаж буй мэдээллийн бүрэн бүтэн байдалд эргэлзээтэй байгаа бол тухайн нисэхийн байгууламжийг үйл ажиллагаанд ашиглахыг хориглоно.

(b) Нисэхийн цахилгаан холбооны үйлчилгээний байгууллагын гэрчилгээ эзэмшигч нь Харилцаа холбооны зохицуулах хорооноос давтамжийн зөвшөөрөл авсан байгууламжаас бусад радионэвтрүүлэгч бүхий нисэхийн байгууламж ажиллуулахыг хориглоно.

(c) Нисэхийн цахилгаан холбооны үйлчилгээний гэрчилгээ эзэмшигч нь 171.109(a) зүйлд заасны дагуу шаардлагаас гажих эсхүл 171.53(b) зүйлд заасны дагуу газар дээрх шалгалт, хэмжилт хийхээс бусад тохиолдолд зөвхөн дараах шаардлагууд хангагдсан нисэхийн байгууламжуудыг ажиллуулна. Үүнд:

(1) Нисэхийн байгууламж нь гэрчилгээ эзэмшигчийн үйл ажиллагааны зааварт тусгагдсан; болон

(2) Нисэхийн байгууламжийн ажиллагаа нь 171.19 зүйлд заагдсаны дагуу хэвлэгдсэн холбогдох мэдээлэлд нийцсэн; болон

(3) нисэхийн байгууламжийн ажиллагаа нь 171.53(a) зүйлд заагдсан шаардлагуудыг хангасан; болон

(4) нисэхийн байгууламжийн ажиллагааны бүрэн бүтэн байдлыг хянах аливаа хяналтын систем нь бүрэн ажиллагаатай байх; болон

(5) нисэхийн байгууламжийн хуваарьт бүх үзлэг, шалгалт нь 171.59(c)(2) болон (3) зүйлүүдэд заагдсан хөтөлбөрийн дагуу хийгдсэн; болон

(6) аливаа нисэхийн байгууламжийг эвдлэх, сүйтгэх эсхүл гаднаас нөлөөлөх нь нислэг үйлдэж буй агаарын хөлгийн аюулгүй ажиллагаанд аюул учруулахаар бол тухайн байгууламж нь 171.55(a) зүйлийн дагуу шаардагдсан гэрчилгээ эзэмшигчийн аюулгүй байдлын хөтөлбөрт тусгагдсан; болон

(7) нисэхийн байгууламж нь (c)(6) зүйлд хамрагдаж байгаа нөхцөлд аюулгүй байдлын хөтөлбөрийн шаардлагууд хангагдсан байна.

171.115 Гэрчилгээ эзэмшигч байгуулагад өөрчлөлт хийгдэх

(a) Нисэхийн цахилгаан холбооны үйлчилгээний гэрчилгээ эзэмшигч нь дараах шаардлагуудыг хангасан байна. Үүнд:

(1) Гэрчилгээ эзэмшигчийн байгууллага, нисэхийн цахилгаан холбооны үйлчилгээ болон байгууламжууд нь мөрдөгдөж буй тодорхойлолтондоо нийцэж буйг бататгах шаардлагын үүднээс үйл ажиллагааны заавартаа өөрчлөлт оруулдаг байх; болон

(2) Үйл ажиллагааны зааварт оруулах нэмэлт, өөрчлөлтүүд энэ дүрмийн шаардлагуудыг хангаж байгааг бататгах; болон

(3) Үйл ажиллагааны заавартаа тусгагдсан өөрчлөлт журмууддаа нийцсэн байх; болон

(4) Гэрчилгээ эзэмшигч нь Үйл ажиллагааны заавартаа нэмэлт өөрчлөлт оруулсны дараа аль болох боломжит хугацаанд үйл ажиллагааны зааврын өөрчлөлтөө хадгалуулахаар Даргад илгээсэн байх; болон

(5) Иргэний нисэхийн аюулгүй ажиллагааг хангах зорилгоор Даргын зүгээс санал гаргавал гэрчилгээ эзэмшигч нь Үйл ажиллагааны заавартаа өөрчлөлт оруулдаг байна.

(b) Гэрчилгээ эзэмшигч нь байгууллагадаа дараах өөрчлөлтийг хийх тохиолдолд ИНЕГ-ын даргаас зөвшөөрөл авна:

(1) Гүйцэтгэх захирал:

(2) Удирдах ажилтнууд:

(3) Аюулгүй байдлын хөтөлбөр:

(4) Гэрчилгээний эрх мэдлийн хүрээнд ажиллуулж буй байгууламжуудын төрлүүд:

(5) Аюулгүй ажиллагааны удирдлагын тогтолцоо - хэрвээ томоохон өөрчлөлт бол.

(c) Гэрчилгээ эзэмшигч нь (b) зүйлд заагдсан аливаа өөрчлөлт оруулах өргөдөл гаргахдаа Даргад ИНЕГ 24171/01 Маягтыг бөглөж ирүүлнэ.

(d) Энэ зүйлийн (b)-д заасан аливаа өөрчлөлт нь Иргэний нисэхийн аюулгүй ажиллагаанд хамааралтай гэж үзсэн тохиолдолд ИНЕГ-ын дарга өөрчлөлт оруулах үед, эсхүл өөрчлөлт оруулсны дараа Нисэхийн цахилгаан холбооны үйлчилгээний гэрчилгээ эзэмшигч нь заавал дагаж мөрдөх тодорхой нөхцөл зааж болно.

(e) Гэрчилгээ эзэмшигч нь (d)-д заасан ИНЕГ-ын даргын тодорхойлсон нөхцлийг заавал дагаж мөрдөнө.

(f) Хэрэв энэ зүйлийн (b)-д заасан өөрчлөлтийг хийснээр Агаарын навигацийн үйлчилгээний техникийн байгууллагын гэрчилгээнд нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлагатай бол гэрчилгээ эзэмшигч нь баталгаажуулалт хийлгүүлэхээр ИНЕГ-ын даргад гэрчилгээг нэн даруй ирүүлнэ.

D Бүлэг. Байгууламжийн техникийн тодорхойлолтууд болон шаардлагууд

171.201 Нэмэлт техникийн тодорхойлолтууд болон шаардлагууд

171.53(a)(1)-д заагдсан нисэхийн байгууламжуудад дараах техникийн тодорхойлолтууд болон шаардлагууд тавигдана. Үүнд:

(1) Нисэхийн цахилгаан холбооны үйлчилгээний гэрчилгээ эзэмшигчийн үйл ажиллагааны зааварт тусгагдсан Чиглүүлэх радио нэвтрүүлэгч бүр нь ИКАО Хавсралт 10-ын Боть I-ийн Бүлэг 3.4-д заагдсан стандартуудыг хангасан байхаас гадна дараах техникийн техникийн тодорхойлолтуудыг хангасан байна:

(i) Цацагдаж байгаа дохио нь

- Залгаж/салгах түлхүүрийн горимоор кодлогдсон 1020 Гц-ийн (нэмэх, хасах 50 Гц-ийн зөвшөөрөгдөх хэлбэлзэлтэй) тон сигналаар модуляцлагдсан тасралтгүй зөөгч; эсхүл
- түлхүүрийн горимоор кодлогдсон үргэлжилсэн зөөгчөөс 1020 Гц-ээр (нэмэх, хасах 50 Гц-ийн зөрүүтэй байж болно) ялгаатай 2 дахь зөөгчөөр танигддаг тасралтгүй зөөгч байна.

(ii) ИКАО Хавсралт 10, Боть I, бүлэг 3.4.8.1 болон 3.4.8.2-т заасан удирдлага хяналтын функцууд нь нисэхийн байгууламж болох Чиглүүлэх радио нэвтрүүлэгч бүрт заавал мөрдөгдөх техникийн тодорхойлолтын шаардлагууд болно;

(iii) нисэхийн байгууламж болох Чиглүүлэх радио нэвтрүүлэгч бүрийн хяналтын систем нь ИКАО Хавсралт 10, Боть I, бүлэг 3.4.8.1 болон 3.4.8.2-д тусгагдсан аль нэг нөхцөл илэрсэн үед анхааруулгыг хяналтын хэсэгт мэдээлдэг байх бөгөөд Чиглүүлэх радио нэвтрүүлэгчийг унтраадаг байна;

(2) Нисэхийн цахилгаан холбооны үйлчилгээний гэрчилгээ эзэмшигчийн үйл ажиллагааны зааварт тусгагдсан Хэт андар давтамжийн Зай хэмжих төхөөрөмж бүр нь ИКАО Хавсралт 10-ын Боть I-ийн Бүлэг 3.5-д заагдсан стандартуудыг хангасан байхаас гадна дараах техникийн техникийн тодорхойлолтуудыг хангасан байна:

(i) ИКАО Хавсралт 10, Боть I, бүлэг 3.5.3.6.3-д заагдсаны дагуу чиглүүлэгчийн кодны таних дохио нь хамгийн цөөндөө нэг удаа, гэхдээ кодын багц нь тэнцүү хэмжээтэйгээр 40 сек бүрт 2-оос ихгүй удаа нэвтрүүлэгдэх ёстой:

(ii) ИКАО Хавсралт 10, Боть I, бүлэг 3.5.3.6.3-т заасан удирдлага хяналтын функцууд нь нисэхийн байгууламж болох Зай хэмжих төхөөрөмж бүрт заавал мөрдөгдөх техникийн тодорхойлолтын шаардлагууд болно.

(3) Нисэхийн цахилгаан холбооны үйлчилгээний гэрчилгээ эзэмшигчийн Үйл ажиллагааны зааварт тусгагдсан радио навигацийн байгууламж бүр нь дараах нөхцлүүдийн аль нэг нь үүссэн тохиолдолд нисэхийн байгууламжийг үйлчилгээнээс салгаж анхааруулгыг холбогдох хяналтын цэгт хүргэдэг байна:

(i) Навигацийн мэдээлэл нь тухайн байгууламжийн тодорхойлогдсон зөвшөөрөгдөх хэмжээнээс хэтэрсэн;

(ii) Дуудлагын дохио алдаа заасан;

(iii) Удирдлага хяналтын систем алдаа заасан.

171.251 Нисэхийн цахилгаан холбооны үйлчилгээний байгууллагын гэрчилгээ эзэмшигч болон өргөдөл гаргагчийн шилжилт

(a) Энэхүү хэсэг нь дараах этгээд бүрт хамааралтай болно. Үүнд:

(1) Нисэхийн цахилгаан холбооны үйлчилгээний гэрчилгээ эзэмшигч;

(2) Нисэхийн цахилгаан холбооны үйлчилгээний өргөдөл гаргагч.

(b) Энэхүү дүрэм хамааралтай байгууллагын хувьд 2018 оны 2-р сарын 1-нээс өмнө:

(1) Дараах зүйлүүдийг заавал хангасан байх шаардлага тавигдахгүй. Үүнд:

(1.i) Хэрвээ байгууллага нь аюулгүй ажиллагааны удирдлагын тогтолцоог хариуцсан удирдах албан тушаалтны оронд дотоод чанар баталгаажуулалт хариуцсан удирдах албан тушаалтантай байгаа бол 171.51(a)(2)(ii) зүйл;

(1.ii) Хэрвээ байгууллага нь аюулгүй ажиллагааны удирдлагын тогтолцоог бүрдүүлэх, нэвтрүүлэх болон хэрэгжүүлэхийн оронд 171.253-т нийцсэн дотоод чанар баталгаажуулалтын тогтолцоог бүрдүүлсэн бол 171.73 зүйл;

(1.iii) 171.77(a)(1A) зүйл;

(1.iv) 171.77(a)(3)(ii) зүйл;

(1.v) 171.77(a)(5A) зүйл; гэвч

(2) 2016 оны 6-р сарын 30-наас өмнө ИНЕГ-ын маягтын хамтаар дараах шаардлагуудыг хангасан нэвтрүүлэх төлөвлөгөөг Даргад ирүүлнэ:

(2.i) Аюулгүй ажиллагааны удирдлагын тогтолцоог нэвтрүүлсэн байхаар санал болож буй огноог агуулсан; болон

(2.ii) 171.73-аар шаардагдсан Аюулгүй ажиллагааны удирдлагын тогтолцоог хэрхэн нэвтрүүлэхээр тухайн байгууллага төлөвлөж буйг харуулсан төлөвлөлт.

(c) Дарга хэрвээ хүлээн зөвшөөрөх боломжтой гэж үзвэл:

(1) Байгууллагын нэвтрүүлэх төлөвлөгөөг батлах; болон

(2) Аюулгүй ажиллагааны удирдлагын тогтолцоог нэвтрүүлсэн байх огноог тогтоож өгнө.

(d) Тодорхой бус байдал үүсгэхгүй байх үүднээс, нэвтрүүлсэн байх огноо нь Аюулгүй ажиллагааны удирдлагын тогтолцоог Даргын зүгээс баталгаажуулах огноо байна.

(e) 171.251(c)(2)-т заасны дагуу Дарга огноог тодорхойлохдоо дараах хүчин зүйлсийг авч үзнэ:

(1) Байгууллагын чадамж, цар хүрээ;

(2) Байгууллагын нарийн түвэгтэй байдал;

(3) Байгууллагын үйл ажиллагаатай салшгүй уялдаатай эрсдлүүд;

(4) Гэрчилгээний хүчинтэй хугацааг сунгах огноо;

(5) Байгуулага эсхүл Удирдах байгууллагад; эсхүл аль алины хувьд эх үүсвэрийн эсхүл хугацааны хувьд нөлөөлөх нөлөөллүүд;

(6) нэвтрүүлсэн байх огноо нь 2018 оны 2-р сарын 1-нээс хойшгүй байна.

(f) Хэрвээ байгууллага нь нисэхийн цахилгаан холбооны үйлчилгээний гэрчилгээний өргөдөл гаргагч бол гэрчилгээ хүссэн өргөдлөө ирүүлэхдээ Аюулгүй ажиллагааны удирдлагын тогтолцоог нэвтрүүлэх төлөвлөгөөний хамт ирүүлнэ.

(g) Энэхүү дүрэм нь 2018 оны 2-р сарын 1-нээс хүчингүй болно.

171.253 Нисэхийн цахилгаан холбооны үйлчилгээний байгууллагын гэрчилгээ эзэмшигч болон өргөдөл гаргагчийн шилжилтийн үеийн дотоод чанар баталгаажуулалт

(a) Энэхүү дүрмээр шаардагдсан журмууд байгуулагад зохижтой бөгөөд байгууллага нь нийцэж байгааг бататгах үүднээс 171.251(b)(1)(ii) зүйлээр шаардагдсан дотоод чанар баталгаажуулалтын тогтолцоог бүрдүүлсэн байна.

(b) Дотоод чанар баталгаажуулалтын тогтолцоо нь дараахыг агуулсан байна. Үүнд:

(1) 171.69 зүйлээр шаардагдсан Байгууламжийн гэмтэл, дутагдлын зөрчлийг шинжлэн шалгах журмыг агуулсан аюулгүй ажиллагааны бодлого болон аюулгүй ажиллагааны бодлогын журмууд; болон

(2) Байгаа хүндрэлүүд болон боломжит хүндрэлүүдийн шалтгаануудыг илрүүлэх үүднээс Дотоод чанар баталгаажуулалтын тогтолцооны хүрээнд тоног төхөөрөмжийн бэлэн байдал, гэмтэл саатал, алдаа болон ажилтнууд, хэрэглэгчдийн санал, гомдол зэргийг агуулсан чанарын үзүүлэлтүүд хяналтанд байгааг бататгах журмууд; болон

(3) Дотоод чанар баталгаажуулалтын тогтолцооны хүрээнд илрүүлэгдсэн үйл ажиллагаанд байгаа хүндрэлүүдийг арилгадаг байхыг баталгаажуулах зорилготой залруулах ажиллагааны журам; болон

(4) Дотоод чанар баталгаажуулалтын тогтолцооны хүрээнд тодорхойлогдсон боломжит хүндрэлүүдийн шалтгаануудыг залруулдаг байхыг баталгаажуулах зорилготой сэргийлэх ажиллагааны журам; болон

(5) Өргөдөл гаргагчийн үйл ажиллагааны зааварт тусгагдсан журмуудад байгууллага нь нийцэж байгааг баталгаажуулах болон аюулгүй ажиллагааны бодлогодоо тогтоосон зорилгодоо хүрэх

үүднээс гаргасан өргөдөл гаргагчийн дотоод аудит шалгалтын хөтөлбөр; болон

(6) Энэхүү дүрмийн шаардлагуудыг хангасан дотоод чанар баталгаажуулалтын тогтолцоо нь зохицсон хэвээр байгаа болон үр ашигтай байгааг баталгаажуулах үүднээс шаардлагатай бол статистик дүн шинжилгээг ашигласан удирдлагын дүн шинжилгээний журам.

(c) Залруулах үйл ажиллагаанд шаардлагатай (b)(3)-аар шаардагдсан журам нь дараах аргачлалуудыг тусгасан байна. Үүнд:

(1) Байгаа чанарын хүндрэлүүдийг хэрхэн шийдвэрлэх; болон

(2) Авч байгаа арга хэмжээ нь үр ашигтай байгааг бататгах үүднээс залруулах арга хэмжээнд хэрхэн хяналт тавих; болон

(3) Залруулах арга хэмжээний үр дүнгээр энэхүү дүрмээр шаардагдаж буй хүрээнд журмуудыг хэрхэн өөрчлөх; болон

(4) Авсан залруулах арга хэмжээний үр дүнтэй байдалд удирдлагын зүгээс хэрхэн үнэлгээ өгөх зэрэг болно.

(d) Сэргийлэх үйл ажиллагаанд шаардлагатай (b)(4) –өөр шаардагдсан журам нь дараах аргачлалуудыг тусгасан байна. Үүнд:

(1) Боломжит чанарын хүндрэлийг хэрхэн арилгах; болон

(2) Авч байгаа арга хэмжээ нь үр ашигтай байгааг бататгах үүднээс сэргийлэх арга хэмжээнд хэрхэн хяналт тавих; болон

(3) Сэргийлэх арга хэмжээний үр дүнгээр энэхүү дүрмээр шаардагдаж буй хүрээнд журмуудыг хэрхэн өөрчлөх; болон

(4) Авсан сэргийлэх арга хэмжээний үр дүнтэй байдалд удирдлагын зүгээс хэрхэн үнэлгээ өгөх зэрэг болно.

(e) (b)(5)-аар шаардагдсан дотоод аудит шалгалтын хөтөлбөр нь:

(1) Аудит үзлэг шалгалт хийгдэх үйл ажиллагааны шинж чанарыг тооцоолон гаргасан аудит шалгалт хийгдэх байршил болон хуваарийг тодорхойлох; болон

(2) Сүүлийн үзлэг шалгалтаас хойш аудит шалгалт хийгдэх үйл ажиллагааг хариуцсан ажилтны авсан сэргийлэх эсхүл залруулах аливаа арга хэмжээнүүдийн үр дүнд хүрсэн байдлыг хэмжих; болон

(3) Аудит шалгалтаар хүндрэлүүд илэрсэн бол аудит үзлэг шалгалт хийгдэж буй үйл ажиллагааг хариуцсан ажилтанд

сэргийлэх эсхүл залруулах ямар арга хэмжээ авахыг шаардах;
болон

(f) (b)(6) –аар шаардагдсан удирдлагын дүн шинжилгээний журам нь:

(1) Дотоод чанар баталгаажуулалтын тогтолцооны байнгын үр дүнтэй байдлыг хадгалахын тулд ямар арга хэмжээ авах шаардлагатай байгааг авч үзэх удирдлагын дүн шинжилгээний хуваарийг тогтоох; болон

(2) (f)(1)-д заагдсан удирдлагын дүн шинжилгээг хариуцах удирдах албан тушаалтныг тодорхойлох; болон

(g) Дотоод чанар баталгаажуулалтын тогтолцоог хариуцсан удирдах албан тушаалтан нь :

(1) Аюулгүй ажиллагааны бодлого болон аюулгүй ажиллагааны бодлогын журмууд нь нисэхийн цахилгаан холбооны үйлчилгээний гэрчилгээ эзэмшигч байгууллагын бүхий л түвшингүүдэд ойлгогдсон, нэвтрүүлэгдсэн болон хэрэгжсэн байхыг бататгах; болон

(2) Аудит шалгалт хийгдэж буй үйл ажиллагаануудыг шууд хариуцаж буй албан тушаалтнуудаас үл хамаарах, сургагдаж бэлтгэгдсэн аудит шалгалтын ажилтнуудаар аудитыг гүйцэтгүүлж байгааг бататгах; болон

(3) Аудит шалгалт хийгдсэн үйл ажиллагааг шууд хариуцаж байгаа албан тушаалтанд аудит шалгалтын тайлан хүргэгдэж байгааг бататгах; болон

(4) Авч байгаа арга хэмжээнүүдийн үр дүнтэй байдалд дүн шинжилгээ хийх үүднээс бүх залруулах болон сэргийлэх арга хэмжээнүүдэд эргэн хяналт тавьж буйг бататгах; болон

(5) Удирдлагын дүн шинжилгээний үр дүн үнэлгээ хийгдсэн болон баримтжуулж, бүртгэгдсэнийг бататгах; болон

(6) Нисэхийн цахилгаан холбооны үйлчилгээний гэрчилгээний эрх хэмжээний хүрээнд ажиллуулж буй байгууламжуудын бүрэн бүтэн байдалд хамааралтай асуудлуудаар гүйцэтгэх захиралтай шууд харилцах боломжтой байна.

(h) Энэхүү дүрэм нь 2018 оны 2-р сарын 1-нээс хүчингүй болно.